



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 268

Улаанбаатар хот

Гэрээний үлгэрчилсэн загвар батлах
тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 16.2 дугаар заалт, Засгийн газрын 2011 оны "Дүрэм батлах тухай" 364 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээний үлгэрчилсэн загвар"-ыг нэгдүгээр, "Гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлт"-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Гэрээний загварыг үндэслэн орон нутгийн онцлогт тохируулан гэрээ байгуулж ажиллахыг аймаг, дүүргийн Засаг дарга, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, дүүргийн Эрүүл мэндийн нэгдийн дарга нарт тус тус даалгасугай.

3. Гэрээний хэрэгжилтэнд явцын хяналт, шинжилгээ хийх, хагас, бүтэн жилээр дүгнэхэд хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Мөнхбат/, Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Я.Амаржаргал/-т тус тус даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 26 дугаар тушаалын 2, 3 дугаар хавсралтыг тус тус хүчингүйд тооцсугай

САЙД



Н.УДВАЛ

D:\barimt\tushaal

002228

53
Эрүүл мэндийн сайдын 2013 оны
07 дугаар сарын 30 өдрийн 265 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

БАТЛАВ
ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ
ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭГДЛИЙН
ДАРГА

БАТЛАВ
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА

.....
ГАРЫН ҮСЭГ

.....
ГАРЫН ҮСЭГ

.....
ГАРЫН ҮСЭГ

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВТЭЙ БАЙГУУЛАХ ГҮЙЦЭТГЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

___ он ___ сар ___ өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Дүрэм батлах тухай” 364 дүгээр тогтоолыг үндэслэн нэг талаас, нөгөө талаас нар нь дүүргийн.....дүгээр хорооны хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхийг харилцан тохиролцож ___ оны ___ сарын ___-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) нэг жилийн хугацаатай байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү гэрээний зорилго ньөрхийн эрүүл мэндийн төв /цаашид төв гэх/-өөс хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй, тасралтгүй үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Гэрээнд захиалагч нь Улаанбаатар хотод нийслэлийн Засаг даргын захирамжийг үндэслэн (ЗГ-ын 2011 оны 364 дүгээр тогтоолын 5.1) дүүргийн Засаг дарга, дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн дарга, орон нутагт аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, гүйцэтгэгч нь Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга байна.
- 1.3. Талууд энэхүү гэрээнд заасныг харилцан зөвшөөрч, хамтран үр бүтээлтэй, шударга ажиллах зарчмыг баримтлан гэрээг үйлдэв.
- 1.4. Талууд гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн биелүүлэх талаар бие биендээ харилцан шаардлага тавих, үүргээ биелүүлээгүй нөхцөлд хариуцлага хүлээх асуудлаар тэгш эрх эдэлнэ.

- 1.5. Гэрээний биелэлтийг хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу талуудын төлөөллийн оролцоотойгоор үнэлж дүгнэнэ.
- 1.6. Хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээ ноцтой зөрчигдсөн, төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалттай холбоотой болон ёс зүйн ноцтой зөрчил гаргасан нь тогтоогдсон, хамт олон баг бүрдүүлж ажиллаагүй, даргын хариуцлагагүй үйл ажиллагаанаас үүдэн тусламж, үйлчилгээ алдагдахад хүрсэн тохиолдлуудад гэрээг талуудын саналаар хугацаанаас нь өмнө цуцална.

Хоёр. Аймаг, Дүүргийн Засаг даргын үүрэг, эрх

2.1 Аймаг, Дүүргийн Засаг дарга нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 2.1.1 Өрхийн эрүүл мэндийн төв /цаашид Төв гэх/ -ийг зориулалтын ажлын байр, дулаан, цахилгаан, цэвэр усаар хангагдах нөхцлийг бүрдүүлэн, төвийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах,
- 2.1.2 Төвийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу хугацаанд нь тогтмол олгох,
- 2.1.3 Нутаг дэвсгэрийн хүн амын бүртгэл, хаягжилтыг тодорхой болгон, үйлчлэх хүрээний хүн амын тоо, шилжилт хөдөлгөөн болон бусад шаардлагатай мэдээллээр улирал тутам хангах,
- 2.1.4 Тухайн баг, хорооны түр оршин суугч болон бүртгэлгүй иргэдийн судалгааг төвтэй хамтран үнэн зөв гарган баталгаажуулах, төвд хүлээлгэн өгөх
- 2.1.5 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шаардлага тавих, дэмжлэг үзүүлэх,
- 2.1.6 Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, өвчлөл эндэгдлээс сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах,
- 2.1.7 Өрхийн эрүүл мэндийн төвөөс хүн амын эрүүл мэндтэй холбогдуулан тавьсан санал, хүсэлтийг шийдвэрлэх, эргэн мэдээлэх
- 2.1.8 “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”, “Эрүүл өрх”, “Эрүүл иргэн” шалгаруулах нийгмийн эрүүл мэндийн аливаа арга хэмжээнд хамтран зохион байгуулах,
- 2.1.9 Эрүүл аюулгүй байдлын индексийг хэрэгжүүлэх,
- 2.1.10 Төвийн ашиглаж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтад аймаг, нийслэлийн өмчийн харилцааны газар хяналт тавих,
- 2.1.11 Шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, автомашинаар хангахад дэмжлэг үзүүлэх,
- 2.1.12 Иргэдийн оршин суугаа хороолол, гудамжны гэрэлтүүлэг, хаягжилтыг шинэчлэн сайжруулж, гамшиг, онцгой байдлын үед түргэн тусламжийн үйлчилгээнд тээврийн хэрэгсэл, хүн хүч, шатахуунаар хангаж ажиллах,
- 2.1.13 Төвийн эмч, ажилчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сургалтанд хамруулахад дэмжлэг үзүүлэх
- 2.1.14 Эмч, ажилтнуудыг хөнгөлөлттэй зээл, орон сууцны хөтөлбөрт хамруулах, гэр, газар, мөнгөн тэтгэмж олгох зэрэг нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх

2.1.15 Аймаг, Дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга нар нь гэрээний шалгуур үзүүлэлтийг өөрсдийн үр дүнгийн гэрээнд тусгаж дүгнэх

2.2 Аймаг, Дүүргийн Засаг дарга нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- 2.2.1 ӨЭМТ-өөс иргэдэд чанартай, хүртээмжтэй тэгш тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар шаардлага тавих
- 2.2.2 Иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд татан оролцуулах, шаардах,
- 2.2.3 Төвийн үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзлэг, шалгалт хийх,
- 2.2.4 Төвийн үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлээс хамааран шагнал, урамшуулалд тодорхойлох, олгох талаар холбогдох байгууллагуудад хандан шийдвэрлүүлэх,
- 2.2.5 Гэрээний гүйцэтгэлийг “бүрэн хангалттай” буюу 90%-ээс дээш үнэлгээтэй биелүүлсэн төвүүдийг тухайн жилийн санхүүжилтийн 5%-аас доошгүй мөнгөн дүнгээр аймаг, дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шагнаж урамшуулах,
- 2.2.6 Тухайн жилд гэрээний гүйцэтгэлийг “хангалтгүй” буюу 69.9%-с доош үнэлгээтэй биелүүлсэн, хууль, эрх зүйн ноцтой зөрчил гаргасан нь тогтоогдсон, хамт олон багаар ажиллах боломжгүйгээс тусламж, үйлчилгээ алдагдахад хүрсэн тохиолдлуудад өөрийн болон Аймаг, Нийслэлийн ЭМГ, Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн саналаар төвийн гэрээг цуцлах

Гурав. Аймгийн Эрүүл мэндийн газар, Дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн үүрэг, эрх

3.1 Аймгийн Эрүүл мэндийн газар, Дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 3.1.1 Төвийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, түүний бие даан ажиллах боломж нөхцлийг бүрдүүлэн ажиллах,
- 3.1.2 “Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS5292-2011” стандартын хэрэгжилт, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдал, чанар, зэрэгт тогтмол хяналт тавиж шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтарсан үзлэг, шалгалт хийн дэмжлэгт удирдлагаар хангах
- 3.1.3 Гамшиг, осол, нийтийг хамарсан халдварт өвчний үед өрхийн эрүүл мэндийн төвийг дайчлах, үүрэг даалгавар өгөх
- 3.1.4 Төвийн үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн санал, хүсэлтийг шуурхай барагдуулж, эргэн мэдээлэх,
- 3.1.5 Эмч, мэргэжилтнүүдийг цаг үеийн болон мэргэжлийн холбогдолтой мэдээллээр тогтмол хангаж ажиллах,
- 3.1.6 Аймгийн Эрүүл мэндийн газар, Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн дарга нар нь гэрээний шалгуур үзүүлэлтийг өөрсдийн үр дүнгийн гэрээнд тусгаж дүгнүүлэх

3.2 Аймгийн Эрүүл мэндийн газар, Дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл нь дараах эрхийг эдэлнэ.

- 3.2.1 Төвийн эмч, мэргэжилтнүүдтэй харилцааны болон мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахих, мэргэжлийн үүргийг чанд биелүүлэх, мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллах,
- 3.2.2 Төвийн үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлээс хамааран шагнал, урамшуулалд тодорхойлох, олгох талаар холбогдох байгууллагуудад хандан шийдвэрлүүлэх,
- 3.2.3 Тухайн жилд гэрээний гүйцэтгэлийг “бүрэн хангалттай” буюу 90%-с дээш үнэлгээтэй биелүүлсэн өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шагнах, үйл ажиллагааг нь сурталчилах
- 3.2.4 Тухайн жилд гэрээний гүйцэтгэлийг “хангалтгүй” буюу 69.9%-с доош үнэлгээтэй биелүүлсэн болон гэрээний 1.6 дугаар заалтын зөрчил дутагдлыг гаргасан тохиолдолд төвийн гэрээг цуцлахаар санал оруулах
- 3.2.5 Гэрээг цуцлах саналаа Нийслэл, Аймгийн эрүүл мэндийн газар, Аймаг, нийслэлийн ЗДТГазарт оруулж шийдүүлэх

Дөрөв. Өрхийн эрүүл мэндийн төвийн үүрэг, эрх

4.1 Өрхийн эрүүл мэндийн төв нь дараах үүргийг хүлээнэ.

- 4.1.1 Эрүүл мэндийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Дүрэм батлах тухай” 364 дүгээр тогтоолд заасан нийтлэг үүргийг хүлээж, үйл ажиллагааг хэрэгжүүлэх
- 4.1.2 Хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй, тэгш, чанартай, хүртээмжтэй чирэгдэлгүй шуурхай үзүүлэх,
- 4.1.3 “Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5292:2011” стандарт болон холбогдох хууль, тогтоол, тушаал, шийдвэрийг мөрдлөг болгон ажиллах,
- 4.1.4 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жагсаалтын дагуу тусламж, үйлчилгээ үзүүлэх,
- 4.1.5 Тусламж, үйлчилгээний чанар сайжруулах талаар эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг биелүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг ханган ажиллах,
- 4.1.6 Төсвийн тухай хуулийн дагуу санхүүжилтийг оновчтой хуваарилан, үр дүнтэй зарцуулах
- 4.1.7 Төвийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, санхүү, хөрөнгөтэй холбоотой зөрчил дутагдал гаргахгүй ажиллах
- 4.1.8 Төвийн үйл ажиллагаатай холбоотой болон удирдах байгууллагуудаас гаргасан тушаал, шийдвэр, үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлэх, тайлагнах
- 4.1.9 Эмнэлгийн мэргэжилтний болон харилцааны ёс зүйн хэм хэмжээ, мэргэжлийн үүргийг чанд биелүүлэх, хамт олон, баг бүрдүүлж ажиллах
- 4.1.10 Ажлын байрны эрүүл аюулгүй орчин бүрдүүлэн, ажиллагсдыг эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах,

- 4.1.11 Төвийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, үнэлгээ дүгнэлт хийн, үр дүнг тооцож ажиллах,
- 4.1.12 Баг хамт олныг бүрдүүлж, тусламж, үйлчилгээг өргөжүүлэх, эмч мэргэжилтнүүдийг чадавхижуулах, ээлтэй орчин бүрдүүлэхэд анхаарч шинэлэг бүтээлч ажлыг нэвтрүүлж ажиллах
- 4.2 **Өрхийн эрүүл мэндийн төв нь дараах эрхийг эдэлнэ.**
- 4.2.1 Эрүүл мэндийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Дүрэм батлах тухай” 364 дүгээр тогтоолд заасан эрхийг эдлэх,
- 4.2.2 Бусад талуудын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлага тавих,
- 4.2.3 Гамшиг, осол, нийтийг хамарсан халдварт өвчний үед өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг журам, зааврын дагуу зохион байгуулж ажиллах,
- 4.2.4 Эмнэлгийн тусламж үзүүлэхэд шаардлагатай тусгаарлах өрөө, багаж, тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгслээр хангагдсан байх,
- 4.2.5 Гамшиг, осол, олон нийтийг хамарсан халдварт өвчний үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, сэргээн босгох төлөвлөгөөг боловсруулж ажиллах,
- 4.2.6 Гэрээний дагуу батлагдсан санхүүжилтийг авах, иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулах чиглэлээр санал, санаачилга, хүсэлт гаргах
- 4.2.7 Эмч, ажилчдыг үзлэг шинжилгээнд хамруулах, хөнгөлөлт үзүүлэх, нийгмийн халамж үйлчилгээнд хамруулах

Тав. Санхүүжилт

- 5.1 Төсвийн санхүүжилтийг нэг иргэнд ногдох зардлаар тооцож улсын төсвөөс олгоно.
- 5.2 Санхүүжилтийг сар бүр бэлэн бус хэлбэрээр өрхийн эрүүл мэндийн төвийн арилжааны банк дахь харилцах дансанд сар бүрийн эхний 10-ны дотор шилжүүлнэ.
- 5.3 Төв нь төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээг холбогдох тушаал, шийдвэрийн дагуу гаргаж, хугацаанд нь хүргүүлнэ.

Зургаа. Төрийн өмчийн хөрөнгийн бүртгэл, ашиглалт

- 6.1.1 Төвийн өмчийг бүртгэх, ашиглахтай холбоотой асуудлыг Монгол Улсын Засгийн газрын “Дүрэм батлах тухай” тогтоолд зааснаар Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн дагуу зохицуулна.
- 6.2 Төв нь Нийслэлийн Өмчийн харилцааны газартай “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” байгуулан, гэрээгээр хүлээсэн үүргээ талууд биелүүлж ажиллана.
- 6.3 Талууд төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдийн эзэмшил, ашиглалтанд шилжүүлэхгүй.

- 58
- 6.4 Эд хөрөнгө болон барилгын хэвийн байдлыг хангахад шаардлагатай урсгал засварын зардлыг төвийн, байрны их засварыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр тус тус гүйцэтгэнэ.
- 6.5 Төв нь төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг үрэгдүүлж, шамшигдуулсан, зориулалтын бусаар ашигласан нь нотлогдсон тохиолдолд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага хүлээнэ.

Долоо. Тайлагнах үйл ажиллагаа

- 7.1 Төв нь үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр гарган аймгийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн нэгдэлд хүргүүлнэ.
- 7.2 Төв нь төвд ногдох иргэний статистик тоог хагас жил тутамд гарган аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.
- 7.3 Төв нь үйл ажиллагааны жилийн эцсийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор холбогдох газарт хүргүүлнэ.

Найм. Гэрээний биелэлтийг дүгнэх

- 8.1 Гэрээний биелэлтийг дүгнэх талуудын төлөөлөл бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:	Аймаг, Дүүргийн ЗДТГ-ын НХХ-ийн дарга
Нарийн бичгийн дарга:	ЭМГ, Нэгдлийн Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хариуцсан орлогч дарга
Гишүүд:	Аймаг, дүүргийн санхүүгийн хэлтсийн төлөөлөл Дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтсийн төлөөлөл Өрх хариуцсан мэргэжилтэн Чанарын менежер Халдвар судлаач Эх барих, эмэгтэйчүүд, Нөхөн үржихүйн ерөнхий зохицуулагч Хүүхэд, өсвөр үеийн ерөнхий зохицуулагч Өрхийн анагаахын мэргэжилтний холбооны төлөөлөл Үйлчилэх хүрээний хүн амаас иргэдийн төлөөлөл 1-3 хүн

- 8.1 Гэрээний биелэлтийг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хагас жил тутамд 1 удаа, нийт 2 удаа дүгнэж, 2 дүнгийн дундажийг жилийн эцсийн гэрээний биелэлтийн дүн гэж тооцно.
- 8.2 Ажлын хэсэг нь холбогдох газруудаас шаардлагатай мэдээллийг авч, төвийн эмч, ажилчид, иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч гэрээний биелэлтийг дүгнэхэд ашиглана.

- 8.4 Гэрээний биелэлтийг онооны дагуу хувьд шилжүүлж тооцно. Жилийн эцсийн гэрээний биелэлтийн дүн 90%-аас дээш бол "А" буюу "Бүрэн хангалттай", 80-89.9% бол "В" буюу "Хангалттай", 70-79.9% бол "С" буюу "Ажил сайжруулах", 69.9%-с доош бол "D" буюу "Хангалтгүй" гэж дүгнэнэ.
- 8.5 Гэрээний биелэлтийг жил бүрийн зургаа, арван хоёрдугаар сарын 25-ны дотор багтаан дүгнэж, дүнг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн, санал, дүгнэлтийн хамт Аймаг, Нийслэлийн Эрүүл мэндийн газарт зургаа, арван хоёрдугаар сарын 30-ны дотор хүргүүлнэ.
- 8.6 Захиалагч нь тэргүүний үйл ажиллагаатай өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг боломжит бүх хэлбэрээр сурталчлан эмч, мэргэжилтнүүдийг алдаршуулах үйл ажиллагааг зохион байгуулна.
- 8.7 Үйл ажиллагаа нь тогтворжиж, "Бүрэн хангалттай" үнэлэгдсэн Өрхийн эрүүл мэндийн төвийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга, Эрүүл мэндийн газраас шагнаж, урамшуулна.
- 8.8 Захиалагч нь "Ажил сайжруулах" үнэлгээтэй дүгнэгдсэн төвтэй гэрээг хагас жилээр байгуулан, ажил сайжруулах хугацаатай үүрэг өгч, биелэлтийг тооцон ажиллана.
- 8.9 Тухайн жилд "Хангалтгүй" үнэлгээ авсан Өрхийн эрүүл мэндийн төвийн гэрээг цуцална.
- 8.10 Өрхийн эрүүл мэндийн төв нь гэрээнд заасан ажил, үйлчилгээг гүйцэтгэхээс татгалзсан тохиолдолд гэрээг цуцална.
- 8.11 Гэрээ цуцалсан тохиолдолд дараагийн өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах хүртэл хугацаанд тусламж, үйлчилгээг тасралтгүй явуулах үүргийг урьд гэрээтэй байсан өрхийн эрүүл мэндийн төв гүйцэтгэнэ.


Ес. Маргаан шийдвэрлэх

- 9.1 Энэ гэрээнд заагдаагүй аливаа асуудлыг Монгол Улсад дагаж мөрдөж буй хууль, тогтоомжоор зохицуулна.
- 9.2 Гэрээтэй холбоотой маргааныг талууд ойлголцож, харилцан тохиролцох замаар шийдвэрлэж болно.
- 9.3 Талууд гэрээтэй холбоотой үүргээ биелүүлээгүй гэж үзвэл асуудлыг холбогдох дээд шатны болон хяналтын байгууллагад тавьж, шийдвэрлүүлнэ.

Арав. Бусад зүйл

- 10.1 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг талынхаа албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчилсэн буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэх эрхгүй.
- 10.2 Гүйцэтгэлийн гэрээг захиалагч, гүйцэтгэгч талуудын оролцоотой жил тутам дүгнэж, цаашид гэрээг байгуулах, цуцлах, өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг шийдэж баталгаажуулна.

10.4 Гэрээг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор байгуулж, 3 хувь үйлдэн талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.



ГЭРЭЭНИЙ ТАЛУУД:

ЗАХИАЛАГЧ :

ГҮЙЦЭТГЭГЧ:

Аймаг, Дүүргийн Засаг даргын
Тамгын газрыг төлөөлж:

Аймгийн ЭМГазар
Дүүргийн Эрүүл
Мэндийн төвийг төлөөлж:

ӨЭМТ-ийг төлөөлж:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____
ТАМГА

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____
ТАМГА

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____
ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр,
дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр,
дансны дугаар]

[Гүйцэтгэгчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкнынэр,
дансны дугаар]

61

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
07 дугаарсарын 30 өдрийн 266 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

1. Аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн нэгдлийн гэрээний шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт	
1	Эрүүл мэндийн нэгдлийн холбогдох мэргэжилтнүүд ӨЭМТ-ийг мэргэжлийн арга зүй, зохион байгуулалтаар хангаж ажилласан байдал	Өрхийн менежер
2		Хүүхдийн мэргэжилтэн
3		Эмэгтэйчүүдийн мэргэжилтэн
4		Халдвар судлаач
5		Сувилгааны алба
6		Чанарын алба
7	Эрүүл мэндийн нэгдлийн удирдлагууд ӨЭМТ-ийг дэмжлэгт удирдлагаар хангаж ажилласан байдлыг: хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, журам, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг тооцож ажилласан баримт, бичиг	
8	Төвийн үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлээс хамааран шагнал урамшуулалд тодорхойлох, холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлсэн байдлыг: шагнуулсан, тодорхойлсон хүний тоо, тушаал, шийдвэр, протокол	
9	Чанарын алба нь арга зүйн дэмжлэгт удирдлагаар хангаж ажилласан байдлыг: хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, журам, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг тооцож ажилласан баримт, бичиг	
10	Төвөөс ирсэн санал, хүсэлтийг цаг алдалгүй зохион байгуулж, шийдвэрлэн эргэн мэдээлсэн байдлыг: шийдвэрлэсэн тухай баримт	

2. Аймаг, Дүүргийн Засаг даргын тамгын газрын гэрээний шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт
1	Гэрээнд заасан хугацааны дагуу санхүүжилтийг олгож, гэрээг дүгнэсэн байдлыг: санхүүжилт олгосон хугацааг харуулах баримт, гэрээг дүгнэж үнэлсэн баримт
2	ӨЭМТ-ийг зориулалтын байр, дулаан, цахилгаан, цэвэр усаар хангагдах нөхцлийг бүрдүүлсэн байдлыг: энэ талаар гарсан гомдол, саналын тоо, шийдсэн арга хэмжээний баримт, хуваарилаж олгосон санхүүжилт, бодитоор хэрэгжүүлсэн ажил
3	Хороодын нутаг дэвсгэрийн хүн амын бүртгэл, хаягжилтыг тодорхой болгон, хүн амын шилжих хөдөлгөөн бусад шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан байдлыг: улирал тутамд шинэчлэн ирүүлсэн мэдээг харуулах баримт
4	Түр оршин суугчдын асуудлыг шийдвэрлэсэн байдлыг: албан ёсны баримт, бүртгэлийг ирүүлсэн байх
5	ӨЭМТ-ээс ирсэн санал, хүсэлтийг шийдвэрлэж, эргэн мэдээлсэн байдлыг: шийдвэрлэсэн тухай баримт, албан тоот

6	Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийг сургах, мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байдлыг: төлөвлөгөөний дагуу сургасан эмч мэргэжилтнүүдийн тоо, олгосон санхүүгийн дэмжлэг
7	Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн байдлыг: үзүүлсэн дэмжлэгийн талаарх тоо, албан баримт
8	Төвийн үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлээс хамааран гэрээнд заасан шагнал урамшуулалыг олгож, хариуцлага тооцсон байдлыг: албан ёсны баримтжуулалт
9	Өрхийн эрүүл мэндийн төвийн засвар үйлчилгээ, орчны тохижилтонд дэмжлэг үзүүлсэн байдлыг: бодит хөрөнгө оруулалтыг харуулсан баримт
10	Иргэдийн өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэлтийн үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн байдлыг: хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, журам, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг харуулсан баримт, бичиг

3. Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт
Байгууллагын удирдлага, төлөвлөлт	Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, Тусгай зөвшөөрөл, дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ зэргээр зөрчил гаргаагүй байх
	Төвийн жил, улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 90%-иас доошгүй байх
	Нөхөрлөлийн үйл ажиллагаа тогтмолжсон, хурлын тэмдэглэл, гишүүнчлэлийн зөрчилгүй ажилласан байх
	Удирдах дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгавар, гаргасан тушаал шийдвэрийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлт
Хүний нөөцийн хөгжил	Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартын дагуу хүний нөөцөөр хангагдсан байдал
	Хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт
	Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн зөрчилгүй байх
	Мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргаагүй байх, /Алдаа гаргасан тохиолдол бүрд -5 оноо хасах (гомдол нь ёс зүйн хурлаар орсон, нотлогдсон байх)
Тусламж, үйлчилгээний чанар	Төвийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөө гарган мөрдөж ажилласан байх
	Мэргэжлийн хяналтын байгууллагын үзлэг, шалгалтаар зөрчил дутагдал илэрч, арга хэмжээ тооцуулсан эсэх
	Тусламж үйлчилгээг өргөжүүлж, иргэдэд ойртуулсан байдал
	Тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ техник, технологи, чанар сайжруулах арга хэрэгслийг нэвтрүүлж үр дүнд хүрсэн байх
	Дотоод хяналтыг сайжруулж тогтмолжуулсан байдал/ Тусламж үйлчилгээний чиглэл бүр дээр дотоод хяналтын хуудас бөглөлт, үнэлгээний дүнг бодитоор гаргах/
Үйлчлүүлэгч иргэдийн сэтгэл	Үйлчлүүлэгчдэд тусламж, үйлчилгээ авах ээлтэй орчин бүрдүүлсэн эсэх байгууллагын соёл, аюулгүй байдлыг хангасан байдал
	Үйлчлүүлэгч иргэдээс санал, хүсэлт, асуулт, сэтгэл ханамжийн судалгааг

ханамж	тогтмол, оновчтой асуумжаар бодитой авч, дүгнэлт хийн, тодорхой ажил зохион байгуулж, эргэн мэдээлсэн байдал
Байгууллагын мэдээ, мэдээлэл технологийн чадавхи	Суурин, хөдөлгөөнт утсан холбоо, компьютер, мэдээллийн хэрэгслийн хүртээмж, чадамж дээшилсэн байх
	Статистик мэдээ мэдээллийн тайланг хугацаанд нь үнэн зөв чанартай гаргаж өгөн дүн шинжилгээ хийсэн байх
Санхүүгийн үйл ажиллагааны тогтвортой байдал	Мэргэжлийн байгууллагын санхүүгийн хяналт шалгалтанд хамрагдсан байх /санхүүгийн зөрчил илрээгүй байх/
	Хөрөнгө оруулалтын бүртгэл, ашиглалт, хамгаалалтын талаар арга хэмжээ авч, хэрэгжүүлсэн байх
	Санхүүгийн мэдээ тайланг хугацаанд нь үнэн зөв гаргаж, өгсөн байх
Баримт бичгийн стандарт мөрдөлт	1.Тушаал, албан тоот, зохион байгуулалт баримт бичгийн боловсруулалт 2.Хөтлөлт 3.Шийдвэрлэлт 4.Архивын бичиг баримтын бүрдүүлэлт 5.Хадгалалт
Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт	Үйлчлэх хүрээний хүн амын судалгааг шинэчлэн, эрүүл мэндийн бүлгээр ангилан дүн шинжилгээ хийсэн байх
	Хүн амын эрүүл мэндийн индексийг гарган, дүн шинжилгээ хийж ажилласан байх
	Нийт нас баралт аймаг, хотын дундажаас ихгүй байх
	Нийт үзлэгээс гэрийн идэвхтэй эргэлт 30% байх
	Нийт үзлэгээс идэвхтэй хяналтын үзлэг 8 % байх
	0-1 насны хүүхдийн эндэгдлийн түвшин аймаг, хотын дунджаас ихгүй байх
	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин аймаг, хотын дунджаас ихгүй байх
	Жилд эрт илрүүлгийн үзлэгийн хувь 40% байх
	Харьяа сургууль, цэцэрлэг, хорооны 0-16 насны хүүхдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд 60 ба түүнээс дээш хувийг хамруулсан байх
	Харьяаллын өрх, хүн амын дунд 0-1 насны 5 хүртэлх насны хүүхдийн тоо, өвчлөлийн судалгаа гаргасан байх
Хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний асуудал	Нярайг амаржих газраас гарсны дараа 72 цагийн дотор 100% эргэсэн байх
	5 хүртэлх насны хүүхдийн өсөлт, хөгжилтийг ЭМС-ын тушаалын дагуу тогтмол хянаж, хооллолтын зөвлөгөө өгөх,
	Төвийн үйл ажиллагаанаас хамаарсан хүүхдийн хоног болоогүй болон гэрийн эндэгдэл гараагүй байх
	Товлолт дархлаажуулалтын хамруулалт 96%-иас доошгүй хамруулсан байх
Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний асуудал	Гэр бүл төлөвлөлт буюу нөхөн үржихүйн насны болон эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн судалгааг гарган, дүгнэлт хийж, ЖСА-д 50-с дээш хувь хамруулсан байх
	Жирэмсний хяналт 100% байх
	Төрсний дараах эх, нярайн хяналт 100% байх
	Гэрийн төрөлт гаргаагүй байх /ӨЭМТ хамааралтай /
	Эхийн эндэгдэл гаргаагүй байх /ӨЭМТ хамааралтай/
Эрүүл мэндийн боловсрол, сургалт сурталчилгаа,	Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байх
	Эрүүл мэндийн сайн дурын идэвхтэнүүдийг бэлтгэх, давтан сургах, хамтран ажиллаж, үр дүнг тооцсон байх
	Үйлчлэх хүрээний хүн амын 30%-иас доошгүйг эрүүл мэндийн боловсрол

эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа	олгох сургалт, сурталчилгаанд хамруулсан байх
	Хүн амын дунд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг өргөнөөр сурталчлах, хамт олон, өрх иргэн болох хөдөлгөөн өрнүүлэх талаар санаачлагатай ажиллан, үр дүнд хүрсэн байх
	Тухайн хүн амын дунд эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийн судалгааг гарган дүн шинжилгээ хийж ажилласан байх
	Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдал
Халдварт өвчний эрт сэрэмжлүүлэг хариу арга хэмжээ	Халдварт өвчний тандалтыг хийж, мэдээ мэдээллийг цаг тухайд нь хүргэж, хариу арга хэмжээг шуурхай авах
	Халдвар хяналтын багийн үйл ажиллагаа тогтмолжсон эсэх
	Сүрьеэ өвчний эрт илрүүлэлт, эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлж хэвшүүлсэн байх